



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/163

Улаанбаатар хот

Элсэлтийн журам, төв болон ур чадварын
шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг
батлах тухай

Монгол улсын Дээд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолоор "Гадаадын болон дотоодын дээд боловсролын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 103 дугаар тогтоолоор "Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрөөс дэмжлэг үзүүлэх журам", Боловсролын сайдын 2024 оны "Оюутан элсүүлэх журам" А/143 дугаар тушаал, Боловсролын сайдын 2024 оны "Босго оноо тогтоох тухай" А/228 дугаар тушаал, "МУБИС-ийн дүрэм"-ийн 4.6.2, "Сургалтын журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2025-2026 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх элсэлтийн журмыг нэгдүгээр хавсралтаар, оюутан элсүүлэх хөтөлбөр, мэргэжлийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар, элсэлтийн төв комиссын бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар, ур чадварын шалгалтын материал боловсруулах комиссын бүрэлдэхүүнийг дөрөвдүгээр хавсралтаар, ур чадварын шалгалтын материал засах комиссын бүрэлдэхүүнийг тавдугаар хавсралтаар, ур чадварын шалгалтын оноог элсэлтийн системд бүртгэх комиссын бүрэлдэхүүнийг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургуулийн элсэлтийн журам, багц хөтөлбөрүүдийг элсэгчдэд танилцуулах, элсэлтийн үйл ажиллагааг чанартай зохион байгуулахыг бүрэлдэхүүний сургуулийн захирал, сургалт, цахим шилжилтийн хэлтэс, бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн алба болон элсэлтийн төв, ур чадварын шалгалтын комисст тус тус үүрэг болгосугай.

3. Оюутан элсүүлэх үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Сургалт, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор (Д.Соронзон)-т үүрэг болгосугай.



20251178

Ректорын 2025 оны 07 сарын 08-дэдрийн
A/163 дугаар тушаалын хавсралт 1

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬД
2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

9987702 A 9521051159

- 1.1. Монгол Улсын Боловсролын Их сургууль (цаашид МУБИС гэх)-ийн бакалавр, магистрантур, докторантурын хөтөлбөрт 2025-2026 оны хичээлийн жилд оюутан элсүүлэхэд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Гадаадын болон дотоодын дээд боловсролын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам" 102 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Багш, багш үзүүлэх журам" 103 дугаар тогтоол, Монгол Улсын Дээд боловсролын төрөөс дэмжлэг үзүүлэх журам" 104 дугаар тогтоол, БШУ-ын сайдын 2024 оны "Оюутан элсүүлэх журам" A/143 хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, БШУ-ын сайдын 2024 оны "Босго оноо тогтоо тухай" A/228 дугаар дугаар тушаал, Боловсролын сайдын 2024 оны "Босго оноо тогтоо тухай" A/228 дугаар дугаар тушаал, МУБИС-ийн Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл, МУБИС-ийн Сургалтын журам, тушаал, бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүд болон энэхүү журам (цаашид элсэлтийн журам гэх)-ыг баримтална.
- 1.2. МУБИС-д элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг "бүртгүүлэгч", зохих шаардлага хангасан бүртгүүлэгчдэд олгох бичиг баримтыг "суралцах эрхийн бичиг", элсүүлэх оюутны тоог "хяналтын тоо", хяналтын тоонд багтан элсэх эрхээс баталгаажуулж, суралцах эрхийн бичиг олгогдсон бүртгүүлэгчийг "элсэгч", элсэлтийн цахим бүртгэлийн систем (www.elset.msu.edu.mn)-ийг "элсэлтийн нэгдсэн систем", элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг "элсэлтийн төв комисс", "элсэлтийн дэд комисс" гэнэ.
- 1.3. МУБИС-ийн захиргааны зөвлөлөөр баталсан элсэлтийн журам, тусгай зөвшөөрөл бүхий сургалтын хөтөлбөр, элсэлтийн еренхий шалгалт (цаашид ЭЕШ гэх)-ын оноо, голч дүн, бөгөөд гишүүд нь бүрэлдэхүүний болон салбар сургуулийн захирал, хөтөлбөрийн дарга, багш, мэргэжилтэн, ажилтны төлөөллөөс бурдэнэ.
- 1.4. МУБИС-ийн элсэлтийн дэд комиссыг бүрэлдэхүүний болон салбар сургуулийн захирал, хөтөлбөрийн албаны дарга, бусад ажилтны төлөөллөөс бурдуулна.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН ТӨВ БА ДЭД КОМИССЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1. Элсэлтийн төв комиссыг МУБИС-ийн ректорын тушаалаар, дэд комиссыг бүрэлдэхүүний болон салбар сургуулийн захирлын тушаалаар тус тус баталгаажуулж байгуулна.
- 2.2. МУБИС-ийн элсэлтийн төв комиссын дарга нь Сургалт, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор, нарийн бичгийн дарга нь Сургалт, цахим шилжилтийн хэлтсийн дарга байх, бөгөөд гишүүд нь бүрэлдэхүүний болон салбар сургуулийн захирал, хөтөлбөрийн дарга, багш, мэргэжилтэн, ажилтны төлөөллөөс бурдэнэ.
- 2.3. МУБИС-ийн элсэлтийн дэд комиссыг бүрэлдэхүүний болон салбар сургуулийн захирал, хөтөлбөрийн албаны дарга, бусад ажилтны төлөөллөөс бурдуулна.

Элсэлтийн төв комиссын үйл ажиллагаа

- 2.4. Элсэлтийн төлөвлөгөө боловсруулж, элсэлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллана.
- 2.5. Оюутан элсүүлэхтэй холбоотой аливаа маргаан, журмаар зохицуулагдах боломжгүй асуудлыг холбогдох нэгжийн саналыг үндэслэн шийдвэрлэнэ.
- 2.6. Элсэлтийн сурталчилгаа, маркетингийн ажилд хяналт тавина.
- 2.7. Элсэлтийн хяналтын тоонд багтаан, шаардлагатай зарим мэргэжлээр намар, өвлийн улиралд нэмэлт элсэлт зохион байгуулж болно.

Элсэлтийн дэд комиссын үйл ажиллагаа

- 2.8. Элсэлтийн төв комисс болон ур чадварын шалгалтын комиссын шийдвэрийн дагуу бүрэлдэхүүний болон салбар сургуульд хуваарилсан дүүрэг, орон нутагт элсэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.
- 2.9. "МУБИС-ийн сурталчилгааны баг"-тай элсэлтийн сурталчилгаа, маркетингийн чиглэлээр хамтарч ажиллана.
- 2.10. Элсэлтийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг элсэлтийн төв комисст тайлагнана.
- 2.11. Шаардлага хангасан элсэгчдэд элсэлтийн төв комиссиос олгосон квотын дагуу МУБИС-ийн урилга, суралцах эрхийн бичиг олгоно.



ГУРАВ. БАКАЛАВРЫН ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТӨЛБӨРТ БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА


- 3.1.1. Бүртгүүлэгч нь тус журмын нэгдүгээр хавсралтад заасан элсэхийг хүссэн тухайн мэргэжлийн хичээлээр 2 жил 6 сарын хүчинтэй хугацаатай ЭЕШ-ын QR код бүхий цахим батламж, Монгол хэл бичгийн шалгалтын босго оноог хангасан QR код бүхий цахим батламж, Боловсролын яамнаас тогтоосон босго оноог хангасан, бүрэн дунд боловсролын гэрчилгээтэй байна.
- 3.1.2. Бүртгүүлэгч нь ур чадварын шалгалт бүхий мэргэжлээр элсэх бол МУБИС-ийн элсэлтийн төв комиссиос баталсан удирдамжийн дагуу тухайн мэргэжлийн ур чадварын шалгалтыг егнэ.
- 3.1.3. Элсэгчийн ур чадварын шалгалтын оноо нь зөвхөн тухайн шалгалтыг өгсөн сургууль, мэргэжлийн хувьд хүчинтэй байна.
- 3.1.4. Ур чадварын шалгалтын оноог дараах аргачлалаар тооцно.

Ур чадварын шалгалтын оноо (анхны оноо)	ЭЕШ-ын оноотой дүйцүүлсэн оноо (хэмжээст оноо)
10-59	200-489
60-64.9	490-519
65-69.9	520-559
70-74.9	560-599
75-79.9	600-639
80-84.9	640-679
85-89.9	680-719
90-94.9	720-759
95-100	760-800

- 3.1.5. Тус журмын хавсралтад заасан ур чадварын шалгалтын босго оноог хангасан нөхцөлд ур чадварын шалгалтад тэнцсэн гэж үзнэ.
- 3.1.6. Элсэлтийн үйл ажиллагааг жилд 2 удаа зохион байгуулна.
- 3.1.7. Элсэн суралцах мэргэжлийн чиглэл (хөтөлбөр)-ээр 3-аас доошгүй жил ажилласан 30-аас дээш насны иргэнийг ЭЕШ-ын оноо харгалзахгүйээр элсүүлэн суралцуулна.
- 3.1.8. МУБИС-аас бакалаврын сургалтын хөтөлбөрт оюутан элсүүлэх хяналтын тоог тухайлсан хөтөлбөр бүрээр дараах үндэслэлээр тодорхойлж, Удирдах зөвлөлөөр хэлэлцэж батална. Үүнд:
- **Багшийн ачаалал:** Багшийн ачаалал, тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үүсэх сургалтын үйл ажиллагааны ачааллыг тооцоолж, элсэлтийн боломжит бүлгийн тоог хөтөлбөр бүрээр тодорхойлох;
 - **Орчин нөхцөл:** Хөтөлбөр бүрээр тодорхойлсон нийт бүлэгт сургалтын анги танхим болон лаборатори хүрэлцээтэй эсэхийг тооцох;
 - **Хичээллэх боломжтой бүлгийн тоонд** үндэслэн элсэлтийн хяналтын тоог тодорхойлоно.

3.2. БАКАЛАВРЫН ХӨРВӨХ, ЭЧНЭЭ, ЗЭРЭГ АХИУЛАХ ХӨТӨЛБӨРТ

БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА



- 3.2.1. Хөрвөх хөтөлбөрт бүртгүүлэгч нь бакалаврын зэрэгтэй байна.
- 3.2.2. Хөрвөх хөтөлбөрт бүртгүүлэгчийн өмнөх бакалаврын дипломын мэдээлэл Боловсролын Яамны дээд боловсролын удирдлага мэдээллийн системд баталгаажсан байна.
- 3.2.3. МУБИС-ийг дээд боловсролын дипломын зэрэгтэй төгссөн төгсгэгчийг зэрэг ахиулан сургана.

3.3 . ЭЛСЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ, БҮРТГЭЛ БАТАЛГААЖУУЛАХ

- 3.3.1. Элсэх хүсэлт гаргагч нь МУБИС-ийн элсэлтийн нэгдсэн системд Боловсролын үнэлгээний төвийн системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан бүртгүүлнэ.
- 3.3.2. Шаардлага хангасан элсэгчдэд суралцах эрхийн бичгийг цахим шуудангаар илгээнэ.
- 3.3.3. Улаанбаатар хотоос элсэгч нь заасан хугацаанд МУБИС дээр өөрийн биеэр ирж бүртгүүлэн, суралцах эрхийн бичгээ баталгаажуулна.
- 3.3.4. Орон нутгаас элсэгч нь 6 сард тухайн аймагт ажиллаж байгаа МУБИС-ийн төлөөлөгчөөс эрхийн бичгээ авч, бүртгэлээ баталгаажуулна.
- 3.3.5. Uriлагаар элсэгч нь элсэлтийн дэд комисс, эсвэл тухайн аймагт ажиллаж буй МУБИС-ийн төлөөлөгчид хандаж, бүртгэлээ баталгаажуулж элсэнэ.
- 3.3.6. Хөрвөх ангийн элсэлтийг хичээлийн жилийн намар болон хаврын улирал эхлэхээс 14 хоногийн өмнө зохион байгуулна.

3.4. ЭЛСЭГЧДИЙН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

- 3.4.1. Бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэгч нь дараах материалыг эх хувиар бүрдүүлж, өөрийн биеэр болон онлайнаар бүртгүүлнэ. Үүнд:
 - Бүрэн дунд боловсрол буюу түүнтэй дүйцэх боловсрол эзэмшсэнийг гэрчлэх баримт бичиг
 - Боловсролын үнэлгээний төвийн системээс хэвлэсэн QR код бүхий ЭШ-ын онооны батламжийн хуудас
 - Монгол хэл бичгийн шалгалтын босго оноог хангасан QR код бүхий цахим батламжийн хуудас
 - МУБИС-д суралцах эрхийн бичиг
 - Иргэний үнэмлэхийн хуулбар (E-Mongolia, ТҮЦ машины лавлагаа)
 - 3x4 хэмжээтэй 2% цээж зураг
- 3.4.2. Суралцах эрхийн бичиг, урилга авсан боловч заасан хугацаанд ирж бүртгүүлээгүй элсэгчийг элсэн суралцахаас татгалзсан гэж үзэн элсэх эрхийг хүчингүйд тооцно.
- 3.4.3. Бакалаврын хөрвөх хөтөлбөрт элсэгч нь дараах материалыг бүрдүүлж, өөрийн биеэр бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн албанд ирж бүртгүүлнэ. Үүнд:
 - Өмнөх бакалаврын диплом
 - Иргэний үнэмлэхийн хуулбар (E-Mongolia, ТҮЦ машины лавлагаа)
 - 3x4 хэмжээтэй 2% цээж зураг
 - Багш мэргэжлээр ажилладаг бол ажлын газрын тодорхойлолт
 - Өргөдөл
- 3.4.4. Бакалаврын зэрэг ахиулах хөтөлбөрт элсэгч нь дараах материалыг бүрдүүлж, өөрийн биеэр бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн албанд ирж бүртгүүлнэ. Үүнд:
 - Өмнөх боловсролын диплом
 - Иргэний үнэмлэхийн хуулбар (E-Mongolia, ТҮЦ машины лавлагаа)

- 3x4 хэмжээтэй 2% цээж зураг
 - Өргөдөл
- 3.4.5. Бакалаврын эчнээс хөтөлбөрт элсэгч нь дараах материалыг бурдуулж өөрийн биеэр бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн албанад ирж бүртгүүлнэ. Үүнд:
- Боловсролын үнэлгээний төвийн системээс хэвлэсэн QR код бүхий ЭШ-ын ондоны батламжийн хуудас (E-Mongolia, ТҮЦ машины лавлагаа)
 - Иргэний үнэмлэхийн хуулбар
 - 3x4 хэмжээтэй 2% цээж зураг
 - Өргөдөл
 - МУБИС-ийн Оюутны журмын 8.8 дахь заалтын дагуу элсэн суралцах бол спортын ёндер зэрэглэлийн тамирчны үнэмлэхийн хуулбар
- 3.4.6. МУБИС-д элсэх материалыг хуурамчаар үйлдвэл үүсэх хариуцлагыг бүртгүүлэгч өөрөө хүлээнэ.



3.5. БАКАЛАВРЫН ЭЛСЭГЧДЭД ОЛГОХ ТЭТГЭЛЭГ, ТЭТГЭМЖ

- 3.5.1. Шаардлага хангасан элсэгч нь Боловсролын зээлийн сангийн зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламжид хамрагдаж болох ба мэдээллийг Боловсролын зээлийн сангийн болон МУБИС-ийн веб хуудаснаас авах боломжтой.
- 3.5.2. Багш бус мэргэжлийн хөтөлбөрт ЭШ-ын 500-аас дээш оноотой эрэгтэй элсэгчдэд эхний жилд МУБИС-ийн 70%-ийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.
- 3.5.3. Багш бус мэргэжлийн хөтөлбөрт ЭШ-ын 500-аас дээш оноотой элсэгчдэд эхний жилд МУБИС-ийн 50%-ийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.
- 3.5.4. Спорт тоглоомын (волейбол) төрлөөр олон улсын тэмцээнд шагналт байранд шалгарсан, улсын аварга шалгаруулах тэмцээнд эхний гурван байр эзэлсэн 5 хүртэлх элсэгчдэд эхний жилд сургалтын төлбөрийн 100%-ийн тэтгэлэг олгоно. Тэтгэлэгт хамрагдах элсэгчдийг Биеийн тамирын сургуулийн саналыг МУБИС-ийн Ректорын зөвлөлийн хурлаар баталгаажуулна.
- 3.5.5. Засгийн газрын тэтгэлэг, тусламж болон МУБИС-ийн тэтгэлгийг элсэгчдэд давхцуулан олгохгүй болно.

ДӨРӨВ. АХИСАН ТҮВШНИЙ СУРГАЛТЫН БОЛОН БАКАЛАВРЫН ГАДААД ОЮУТНЫ ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. МОНГОЛ СУРАЛЦАГЧДЫН БҮРТГЭЛ, ЭЛСЭЛТ

- 4.1.1. Ахисан түвшний хөтөлбөрийн алба нь ахисан түвшний сургалтын бүртгэл, элсэлтийг зохион байгуулж, суралцах эрхийн бичиг олгоно.
- 4.1.2. Элсэлтийн зарыг сургалт эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө сургуулийн вэб сайтад байршуулж, элсэлтийн нэгдсэн системийг нээнэ.
- 4.1.3. Ахисан түвшний хөтөлбөрт бүртгүүлэгч нь элсэлтийн нэгдсэн системийн талбарыг үнэн зөв бөглөж, дараах бичиг баримтуудыг цахим хэлбэрээр хавсаргана.
- Цээж зураг (сүүлийн 3 сард авхуулсан байх)
 - Бакалавр болон магистрын диплом, хавсралтын хамт
- 4.1.4. Бүртгүүлэгчийн өмнөх шатны боловсролын мэдээлэл нь Боловсролын Яамны дээд боловсролын удирдлага мэдээллийн системд баталгаажсан байна.
- 4.1.5. Бакалаврын дипломын голч дүн 2.7-оос дээш тохиолдолд магистрын хөтөлбөрт, магистрын дипломын голч дүн 3.3-аас дээш тохиолдолд докторын хөтөлбөрт шууд элсүүлнэ. Голч дүн хүрэхгүй тохиолдолд мэргэжлийн шалгалт авах бөгөөд шалгалтад 70%-аас дээш оноотой тохиолдолд элсүүлэн суралцуулна. Мэргэжлийн шалгалтыг тухайн мэргэжлийн тэнхим зохион байгуулна.

- 4.1.6. Элсэн суралцах эрхийн бичиг авсан бүртгүүлэгчдийн цахим шуудангийн хаягаар сургалтын тухай мэдээллийг хүргэнэ.
- 4.1.7. Өмнө суралцсан хөтөлбөрөөс өөр чиглэлээр суралцах бол сургалтын агуулгын залгамж холбоог хангахад шаардагдах зөрөө хичээлийг нэмэлтээр судална. Нэмэлтээр үзсэн хичээлийг тухайн хөтөлбөрийн үндсэн багц цагт тооцохгүй.
- 4.1.8. МУБИС-ийн бакалавр, магистрын дипломын голч оноо 3.7-оос дээш төгсөгчдөд магистр, докторын хөтөлбөрт сургалтын төлбөрийн 20%-ийн тэтгэлэг олгоно.
- 4.1.9. Хамтын ажиллагааны гэрээтэй байгууллагын багш, ажилтанд сургалтын төлбөрийн 15-20%-ийн тэтгэлэг олгоно.
- 4.1.10. Шаардлага хангасан суралцагч Боловсролын зээлийн сангийн зээл, тэтгэлэгт хамрагдаж болно.

4.2. ГАДААД СУРАЛЦАГЧДЫН БҮРТГЭЛ, ЭЛСЭЛТ

- 4.2.1. Боловсролын Яамны "Журам шинэчлэн батлах тухай" тушаалын "Оюутан элсүүлэх журам"-ын 2.4.4, 2.4.5, 3.3-т заасны дагуу гадаад иргэдийг элсүүлэн суралцуулна.
- 4.2.2. Гадаадын иргэн нь МУБИС-ийн элсэлтийн нэгдсэн системд бүртгүүлнэ. Элсэлтийн үйл ажиллагааг бакалаврын зэрэг олгох сургалтын хувьд жилд нэг удаа буюу 8 сард, ахисан түвшний сургалтын хувьд жилд гурван удаа 9, 11, 1 саруудад зохион байгуулна.
- 4.2.3. Бүртгүүлэгч нь монгол хэлний түвшин тогтоо шалгалтад 71 ба түүнээс дээш оноо авч тэнцэнэ. 70-аас доош оноо авсан тохиолдолд монгол хэлний бэлтгэл ангид хэлний түвшнээс шалтгаалан 6-18 сар суралцана.
- 4.2.4. Бүртгүүлэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлж элсэнэ. Үүнд:
- Гадаад паспортын хуулбар (Гадаад паспортын эхний хуудас болон 180 хоногоос доошгүй хугацаанд хүчинтэй болохыг илтгэсэн хуудсыг дэлгэмэл байдлаар сканердаж хавсаргах)
 - Тухайн улсын иргэний үнэмлэх (биеийн байцаалт), баталгаат орчуулгын хамт
 - Эрүүл мэндийн хуудас
 - 3x4 хэмжээтэй 4% цээж зураг
 - Бакалаврын хөтөлбөрт бүртгүүлэгч нь баталгаат орчуулга бүхий бүрэн дунд боловсролын гэрчилгээ болон Монгол Улсын элсэлтийн ЭШ-тай дүйцэхүйц тухайн улсын элсэлтийн шалгалтын оноотой байна. Тус шалгалтын оноог МУБИС-ийн элсэлтийн төв комиссоос байгуулагдсан ажлын хэсэг дүйцүүлэн тооцож элсүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.
 - Магистр, докторын хөтөлбөрт бүртгүүлэгч өмнөх боловсролын зэргийн диплом болон төгсөлтийн дипломын хуулбар, монгол хэлээр орчуулсан баталгаат орчуулга
 - Сургууль төгссөнийг гэрчлэх QR код бүхий тодорхойлолт болон монгол хэлээр орчуулсан баталгаат орчуулга
 - Бүртгэлийн хураамж төлсөн баримт (МУБИС-ийн бүрэлдэхүүний болон салбар сургуулийн тухайн дансанд шилжүүлнэ. Гүйлгээний утга хэсэгт "Гадаад паспорт дээрх нэр, паспортын дугаар"-ыг бичсэн байна.)
- 4.2.5. Элсэн суралцах эрхийн бичиг авсан бүртгүүлэгчдийн цахим шуудангийн хаягаар сургалтын тухай мэдээллийг хүргэнэ.
- 4.2.6. Өмнө суралцсан хөтөлбөрөөс өөр чиглэлээр суралцах бол сургалтын агуулгын залгамж холбоог хангахад шаардагдах зөрөө хичээлийг нэмэлтээр судална. Нэмэлтээр үзсэн хичээлийг тухайн хөтөлбөрийн үндсэн багц цагт тооцохгүй.

ТАВ. ТӨЛБӨР ХУРААМЖ

- 5.1. Бакалавр, магистрантур, докторантурын элсэлтийн бүртгэлийн хураамж 30.000 төгрөг байна.
- 5.2. Бакалаврын элсэгчдийн бичиг баримт буцаалтын хураамж 100.000 төгрөг байна.

- 5.3. Гадаад элсэгчийн бакалавр, магистрантур, докторантурын элсэлтийн бүртгэлийн хураамж 120.000 төгрөг байна.
- 5.4. МУБИС-д элсэх гадаад оюутнаас авах монгол хэлний түвшин тогтоох шалгалтын хураамж 100.000 төгрөг, бусад сургуульд элсэгчдээс авах хураамж 130.000 төгрөг байна.

ЗУРГАА. ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ

- 6.1. Журмын хэрэгжилтийг элсэлтийн тушаал гарахаас өмнө Чанарын баталгаажуулалт, мониторингийн алба болон Сургалт, цахим шилжилтийн хэлтсээс үнэлж, тайланг МУБИС-ийн Ректорын зөвлөлийн хуралд танилцуулна.
- 6.2. Журамд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд МУБИС-ийн Ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцэн батлуулна.

Ректорын 2025 оны 04 сарын
08. едрийн дугаар хөвсрэлт 2
163

**МУБИС-ИЙН 2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТӨЛБӨРТ
ЭЛСЭЛТ АВАХ ХӨТӨЛБӨР /МЭРГЭЖИЛ/-ИЙН ЖАГСААЛТ**

Тайлбар: *Дээд боловсролын эрэлттэй мэргэжил

9087702 5021051159

№	Индекс	Хөтөлбөр	Мэргэжил	ЭШ-ын оноо тооцох хичээл, элсэлтийн босго оноо			Судлах кредит	Суралцах хугацаа	
				Хичээл-1	Хичээл-2				
БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН СУРГУУЛЬ									
1	011101	Боловсрол судлал	Боловсрол судлаач	Монгол хэл Нийгэм судлал	490	Математик Англи хэл	450	122	4 жил
2	031301	Сэтгэл судлал*	Сэтгэл судлаач	Нийгэм судлал Математик	490	Монгол хэл Англи хэл	490	122	4 жил
3	092301	Нийгмийн ажил*	Нийгмийн ажилтан	Нийгэм судлал Англи хэл	490	Монгол хэл Математик	490	122	4 жил
4	031301	Сэтгэл судлал*	Сэтгэл судлаач, сургуулийн сэтгэл зүйч	Нийгэм судлал Математик	490	Монгол хэл Англи хэл	490	144	4 жил
5	092301	Нийгмийн ажил*	Нийгмийн ажил, хүүхдийн арга зүйч	Нийгэм судлал Англи хэл	490	Монгол хэл Математик	490	138	4 жил
6	011426	Багш, насан туршийн боловсрол	Насан туршийн боловсролын багш	Монгол хэл Нийгэм судлал	450	Үр чадварын шалгалт	490	122	4 жил
7	011428	Багш, тусгай хэрэгцээт боловсрол*	Тусгай хэрэгцээт боловсролын багш	Монгол хэл Нийгэм судлал	450	Үр чадварын шалгалт	490	122	4 жил
МАТЕМАТИК, БАЙГАЛИЙН УХААНЫ СУРГУУЛЬ									
8	011401	Багш, математикийн боловсрол*	Математикийн багш	Математик Физик	490	Үр чадварын шалгалт	490	123	4 жил
9	011403	Багш, мэдээлэл зүйн боловсрол	Мэдээлэл зүйн багш	Математик	490	Үр чадварын шалгалт	490	123	4 жил
10	011409	Багш, физикийн боловсрол*	Физикийн багш	Физик Математик	490	Үр чадварын шалгалт	490	123	4 жил
11	011405	Багш, химийн боловсрол*	Химиин багш	Хими Математик	490	Үр чадварын шалгалт	490	123	4 жил

12	011411	Багш, газарзүйн боловсрол*	Газарзүйн багш	Газарзүй Нийэм судлал	490	Ур чадварын шалгалт	490	123	4 жил
13	011439	Багш, эрүүл мэндийн боловсрол, ага зүй	Эрүүл мэндийн багш, ага зүй	Нийгэм судлал Биологи	450	Ур чадварын шалгалт	490	135	4 жил
14	061302	Программ хангамж*	Программ хангамжийн инженер	Математик Физик	490	Нийгэм судлал Англи хэл	450	121	4 жил
15	011407	Багш, биологийн боловсрол*	Биологийн багш	Биологи Хими	490	Ур чадварын шалгалт	490	123	4 жил

НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ СУРГУУЛЬ

9087702 - 50210511С3

16	011413	Багш, нийгмийн ухааны боловсрол	Нийгмийн ухааны багш	Нийгэм судлал Түүх	490	Ур чадварын шалгалт	490	122	4 жил
17	011413	Багш, нийгмийн ухааны боловсрол	Түүх, нийгмийн ухааны багш	Нийгэм судлал Түүх	490	Ур чадварын шалгалт	490	152	4-4.5 жил
18	011413	Багш, нийгмийн ухааны боловсрол	Түүх багш	Нийгэм судлал Түүх	490	Ур чадварын шалгалт	490	122	4-4.5 жил
19	032202	Архив судлал	Архив, албан хэрэг хөтлөлт	Түүх Монгол хэл	490	Нийгэм судлал Математик	450	121	4 жил
20	101502	Түүх, соёлын аялал жуулчлал	Түүх, соёлын аялал жуулчлал	Түүх Англи хэл	490	Ур чадварын шалгалт	490	122	4 жил
21	011430	Багш, монгол хэл уран зохиолын боловсрол	Монгол хэл, уран зохиолын багш	Монгол хэл	490	Ур чадварын шалгалт	490	122	4 жил
22	023201	Хэл, уран зохиол	Хэл, уран зохиол судлаач	Монгол хэл	490	Нийгэм судлал Түүх	490	123	4 жил
23	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Англи хэлний багш	Англи хэл Орос хэл	490	Ур чадварын шалгалт	490	122	4 жил
24	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Хятад хэлний багш	Англи хэл Орос хэл	490	Ур чадварын шалгалт	490	122	4 жил
25	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Солонгос хэлний багш	Англи хэл Орос хэл	490	Ур чадварын шалгалт	490	122	4 жил
26	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Япон хэлний багш	Англи хэл Орос хэл	490	Ур чадварын шалгалт	490	122	4 жил
27	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Герман хэлний багш	Англи хэл Орос хэл	490	Ур чадварын шалгалт	490	122	4 жил
28	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Герман, англи хэлний багш	Англи хэл Орос хэл	490	Ур чадварын шалгалт	490	152	4.5 жил
29	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Орос, англи хэлний багш	Англи хэл Орос хэл	490	Ур чадварын шалгалт	490	152	4.5 жил
30	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Орос хэлний багш	Англи хэл Орос хэл	490	Ур чадварын шалгалт	490	122	4 жил

48	021202	Хувцас дизайн	Хувцас дизайн	Математик Англи хэл	450	Ур чадварын шалгалт	490	126	4 жил
49	021301	Уран зураг	Зураач	Түүх Нийгэм судлал	450	Ур чадварын шалгалт	490	126	4 жил
50	018801	Багш, техник спортын дасгалжуулагч	Техник спортын дасгалжуулагч, багш	Математик Монгол хэл	450	Ур чадварын шалгалт	490	135	4 жил

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

51	011201	Багш, сургуулийн өмнөх боловсрол*	Сургуулийн өмнөх боловсролын багш	Монгол хэл Нийгэм судлал	440	Ур чадварын шалгалт	490	124	3.5-4 жил
----	--------	-----------------------------------	-----------------------------------	-----------------------------	-----	---------------------	-----	-----	-----------

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ САЛБАР СУРГУУЛЬ

52	011301	Багш, бага боловсрол*	Бага ангийн багш	Монгол хэл Математик	430	Ур чадварын шалгалт	430	132	4 жил
53	011201	Багш, сургуулийн өмнөх боловсрол*	Сургуулийн өмнөх боловсролын багш	Монгол хэл Нийгэм судлал	430	Ур чадварын шалгалт	430	124	3.5-4 жил
54	011430	Багш, монгол хэл уран зохиолын боловсрол	Монгол хэл, уран зохиолын багш	Монгол хэл Математик	430	Ур чадварын шалгалт	430	122	4 жил
55	011401	Багш, математикийн боловсрол*	Математикийн багш	Физик	430	Ур чадварын шалгалт	430	123	4 жил
56	011413	Багш, нийгмийн ухааны боловсрол	Түүх, нийгмийн ухааны багш	Нийгэм судлал Түүх	430	Ур чадварын шалгалт	430	152	4-4.5 жил
57	092301	Нийгмийн ажил*	Нийгмийн ажилтан	Англи хэл Математик	430	Монгол хэл Математик	430	122	4 жил
58	031301	Сэтгэл судлал*	Сэтгэл судлаач	Нийгэм судлал Математик	430	Монгол хэл Англи хэл	430	122	4 жил

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ САЛБАР СУРГУУЛЬ

59	011301	Багш, бага боловсрол*	Бага ангийн багш	Монгол хэл Математик	430	Ур чадварын шалгалт	430	132	4 жил
60	011201	Багш, сургуулийн өмнөх боловсрол*	Сургуулийн өмнөх боловсролын багш	Монгол хэл Нийгэм судлал	430	Ур чадварын шалгалт	430	124	3.5-4 жил
61	011424	Багш, хөгжмийн боловсрол*	Хөгжмийн багш	Монгол хэл Нийгэм судлал	430	Ур чадварын шалгалт	430	126	4 жил
62	011301	Багш, бага боловсрол* /хамтарсан хөтөлбөр/	Бага ангийн багш	Монгол хэл Математик	430	Ур чадварын шалгалт	430	132	4 жил
63	011201	Багш, сургуулийн өмнөх боловсрол* /хамтарсан хөтөлбөр/	Сургуулийн өмнөх боловсролын багш	Монгол хэл Нийгэм судлал	430	Ур чадварын шалгалт	430	124	3.5-4 жил

31	011435	Багш, гадаад хэлний боловсрол	Япон, англи хэлний багш	Англи хэл Орос хэл	490	Ур чадварын шалгалт	490	152	4.5 жил
32	032101	Сэтгүүл зүй	Сэтгүүлч	Монгол хэл Нийгэм судлал	490	Ур чадварын шалгалт	490	123	4 жил

БАГШИЙН СУРГУУЛЬ

33	011301	Багш, бага боловсрол*	Бага ангийн багш	Монгол хэл Математик	450	Ур чадварын шалгалт	490	132	3.5-4 жил
34	011424	Багш, хөгжмийн боловсрол*	Хөгжмийн багш	Монгол хэл Нийгэм судлал	450	Ур чадварын шалгалт	490	126	4 жил

БИЕИЙН ТАМИРЫН СУРГУУЛЬ

35	011437	Багш, биесийн тамирын боловсрол	Биесийн тамирын багш	Монгол хэл Нийгэм судлал	450	Ур чадварын шалгалт	490	125	4 жил
36	101402	Биесийн тамирын арга зүй	Биесийн тамирын арга зүйч	Монгол хэл Нийгэм судлал	490	Ур чадварын шалгалт	490	124	4 жил
37	011437	Багш, биесийн тамирын боловсрол	Биесийн тамирын багш, арга зүйч	Монгол хэл Нийгэм судлал	450	Ур чадварын шалгалт	490	147	4.5-5 жил
38	011437	Багш, биесийн тамирын боловсрол	Биесийн тамирын багш, арга зүй, хөдөлгөөн засалч	Монгол хэл Нийгэм судлал	450	Ур чадварын шалгалт	490	147	4 жил
39	101401	Спортын дасгалжуулагч	Спортын дасгалжуулагч, биесийн тамирын багш	Монгол хэл Нийгэм судлал	490	Ур чадварын шалгалт	490	160	4.5-5 жил
40	101401	Спортын дасгалжуулагч	Спортын дасгалжуулагч	Монгол хэл Нийгэм судлал	490	Ур чадварын шалгалт	490	124	4.5-5 жил
41	101503	Спорт аялал жуулчлал	Спорт аялал жуулчлал	Нийгэм судлал Англи хэл	490	Ур чадварын шалгалт	490	122	3.5-4 жил
42	032101	Сэтгүүл зүй	Спортын сэтгүүлч	Монгол хэл Нийгэм судлал	490	Ур чадварын шалгалт	490	121	3.5-4 жил

ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ

43	011419	Багш, дүрслэх урлагийн боловсрол	Дүрслэх урлагийн багш	Нийгэм судлал Математик	460	Ур чадварын шалгалт	490	125	3.5-4 жил
44	011422	Багш, дизайн зураг зүйн боловсрол	Дизайн зураг зүйн багш	Нийгэм судлал Математик	460	Ур чадварын шалгалт	490	125	3.5-4 жил
45	011420	Багш, дизайн технологийн боловсрол	Дизайн технологийн багш	Нийгэм судлал Математик	460	Ур чадварын шалгалт	490	124	3.5-4 жил
46	021105	График дизайн*	Компьютер график дизайн	Математик Англи хэл	450	Ур чадварын шалгалт	490	125	4 жил
47	021105	График дизайн*	Мультимедиа дизайн	Математик Англи хэл	450	Ур чадварын шалгалт	490	125	4 жил